

# **УКРАИН улсад суралцуулах сонгон шалгаруулалт зарлагдлаа**

## **Мэргэжлийн чиглэл:**

### **Украин-25:**

Биеийн тамир, уул уурхайн инженер, нисэхийн инженер, авто замын инженер, хөдөө аж ахуйн инженер, төмөр замын инженер, логистик, авто тээвэр зохион байгуулалт, барилгын инженерийн чиглэлээр, доктор байгалийн ухааны чиглэлээр суралцуулна /Орос, Англи хэл дээр суралцах боломжтой/.

## **Нэг. Тавигдах шаардлага**

Бакалавр

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн иргэн, Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн 1, 2 дугаар ангид 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй суралцаж байгаа

Магистр, доктор

- Магистрант: бакалаврын зэрэгтэй, 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй, 2-оос доошгүй жил ажилласан ажлын туршлагатай, 35 хүртэлх насны;
- Докторант: магистр зэрэгтэй, 3.0 ба түүнээс дээш голч дүнтэй, 2-оос доошгүй жил ажилласан ажлын туршлагатай, 45 хүртэлх насны

## **Хоёр. Бүрдүүлэх баримт бичиг:**

Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежийн 1, 2 дугаар ангид суралцаж буй иргэн:

- Цахим өргөдөл
- Суралцаж буй сургуулийн тодорхойлолт;
- Дүнгийн хуулбарын эх хувь /голч дүнтэй/;
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, дүнгийн хавсралтын нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Сонгон шалгаруулалтад орохыг дэмжсэн сургуулийн захирлын албан бичиг;
- Бүртгэлийн хураамж 15000 төгрөг төлсөн баримт;
- Хэлний бэлтгэлийн гэрчилгээ /оноо/

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн иргэн

- Цахим өргөдөл
- Сонгон шалгаруулалтад орохыг дэмжсэн сургуулийн захирлын албан бичиг;
- Сүүлийн хагас жилийн дүнгийн тодорхойлолт;
- Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Бүртгэлийн хураамж 15000 төгрөг төлсөн баримт;
- Гадаад паспорт

Магистр, докторын сургалтад бүртгүүлсэн иргэд

- Цахим өргөдөл
- Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;
- Хамгийн сүүлд ажиллаж байсан эсвэл ажиллаж байгаа байгууллагын ажил, зан байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт;
- Дээд боловсролын зэргийн дипломууд, тэдгээрийн дүнгийн жагсаалтын нотариатаар баталгаажуулсан хуулбар (Боловсролын баримт бичиг монгол хэл дээр биш бол монгол хэл дээрх албан ёсны орчуулгыг хавсаргах);
- Англи хэлний түвшин тодорхойлох олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалт өгсөн бол хуулбарыг хавсаргах /Шалгалтыг 2016 оны 9 сараас хойш өгсөн байх/
- Эссэ, Суралцах хөтөлбөр, төлөвлөгөө (Англи, Монгол хэл дээр 500-аас цөөнгүй үтгэй байх);
- Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт (Докторын сургалтад өргөдөл гаргах иргэд зайлшгүй хавсаргах, магистрын сургалтад өргөдөл гаргах иргэд хавсаргах шаардлагагүй ч хавсаргавал давуу талтай.)
- Бүртгэлийн хураамж 15000 төгрөг төлсөн баримт;
- Гадаад паспорт

### Гурав. Бүртгэл

2019 оны 02 дугаар сарын 11-нээс 03 сарын 07-ны өдрийн 17.00 цаг хүртэл <https://scholarship.esis.edu.mn...> цахим хаягаар шинээр эрх нээж бүртгэл хийнэ. Холбоосоор хандан, хэрэглэгчийн эрх үүсгэн нэвтэрч, **цахим өргөдлийг** бөглөж, Цахим өргөдөлд дурдсан баримт бичиг тус бүрийг PDF хэлбэрээр “баримт бичиг” хэсэгт хавсаргана.

Бүртгэлийн хураамж 15000 төгрөгийг Төрийн сан дахь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны **100900015003** тоот дансанд тушаана. Хураамж төлсөн баримтад бүртгүүлэгчийн овог, нэр, регистрийн дугаар, утасны дугаар, гүйлгээний утга буюу аль улсын ямар тэтгэлэгт бүртгүүлэх тухай мэдээллийг заавал оруулах шаардлагатай.

### Дөрөв. Сонгон шалгаруулалт

Сонгон шалгаруулалтад оролцогч дараах шалгалтыг өгнө:

*Бакалаврын сургалтад бүртгүүлсэн  
иргэд математик, англи хэлний нэгдсэн шалгалтыг төстийн хэлбэрээр өгнө.*

2019 оны 03 дугаар сарын 9-ний өдрийн 10.00 цагт Математик, 11:30 Англи хэлний шалгалтыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 1-р байранд тус тус зохион байгуулна. Шаардлага гарвал шалгалт авах нэмэлт байр гаргаж, шалгалтын үеэр жич зарлана.

Бүртгүүлэгч шалгалт эхлэхээс 30 минутаас 1 цагийн өмнө, иргэний үнэмлэхтэй ирэх шаардлагатай. Иргэний үнэмлэхгүй иргэнийг шалгалтад оруулахгүй.

Бичгийн шалгалтын дүн болон ярилцлагад орох иргэдийн нэрс, ярилцлагын цагийн хуваарийг 2019 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 18.00 цагт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас дахь “гадаадад суралцах” цэсэд зарлана.

Ярилцлагыг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 10 цагт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 1-р байранд зохион байгуулна. Ярилцлагад ирэхдээ бүртгэлд ирүүлсэн бичиг баримтаяа эх хувиар нь авч ирэх шаардлагатай.

Ярилцлагад тэнцсэн иргэдийн нэrsийг 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас дахь “гадаадад суралцах” цэсэд зарлана.

*Магистр, докторын сургалтад бүртгүүлсэн иргэд:*

Бүртгүүлэгчдийн ирүүлсэн бичиг баримтад үнэлэлт, дүгнэлт өгөх хэлбэрээр ярилцлагад орох иргэдийн нэrsийг тодруулж, ярилцлагын цагийн хуваарь, байршилыг 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 18.00 цагт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны цахим хуудас дахь “гадаадад суралцах” цэсэд зарлана.

Ярилцлагыг 2019 оны 03 дугаар сарын 12, 13-ны өдөр зохион байгуулна

Бүртгэлийн асуудлаарх лавлагаа, мэдээллийг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны +51 267131 утсаар авч болно.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ